

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний бүртгэлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

1/12¹ дүгээр зүйл:

12¹ дүгээр зүйл.Хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл

12¹.1.Хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг өөрчлөхдөө хүүхдийн эцэг /эх/, асран хамгаалагч, харгалзан дэмжигч дараах баримт бичгийг бүрдүүлж, оршин суугаа газрын улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ:

12¹.1.1.хүүхдэд өөрийн овог нэрийг өгөх хүний өргөдөл;

12¹.1.2.хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг өөрчлөхдөө хүүхдийн эцэг /эх/, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл;

12¹.1.3.хүүхэд долоон насанд хүрсэн бол хүүхдийн өөрийн зөвшөөрөл;

12¹.1.4.хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад байгаа хүүхэд бол тухайн байгууллагын зөвшөөрөл.

12¹.2.Энэ зүйлийн 12¹.1.1, 12¹.1.2-т заасан баримт бичгийг нотариатаар гэрчлүүлсэн байна.

12¹.3.Хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг өөрчилсөн шийдвэрийг хүчингүй болсонд тооцсон тухай шүүхийн шийдвэрийг үндэслэн улсын бүртгэгч тухайн бүртгэлд өөрчлөлт оруулж, төрсний бүртгэлийг сэргээнэ.

2/6 дугаар зүйлийн 6.1.4 дэх:

“6.1.4.хэрэв нөхөн үржихүйн туслах технологийг ашиглаж хүүхэдтэй болсон бол Гэр бүлийн тухай хуулийн 28.1-д заасан гэрээ.”

2 дугаар зүйл.Иргэний бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсгийн “эрх бүхий байгууллагын” гэснийг “шүүхийн” гэж, мөн зүйлийн 11.6-11.8 дахь хэсгийн дугаарыг “11.1-11.3” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Иргэний бүртгэлийн тухай 11 дүгээр зүйлийн 11.1-11.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

“32.4.Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 129.1.7-д заасан хугацаанд шүүхийн эвлэрүүлэн зуучлагч гэрлэгчдийг эвлэрүүлэхэд дэмжлэг үзүүлж дараах арга хэмжээг авна:

32.4.1.гэрлэгчидтэй хамтарсан болон ганцаарчилсан уулзалт хийж, гэрлэлт цуцлуулах болсон шалтгаан үндэслэлтэй эсэхийг тогтоох, гэрлэлт цуцлуулахын үр дагаврыг тайлбарлах;

32.4.2.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32.4-т зааснаас гадна өмгөөлөгч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулж, гэрлэгчдэд зөвлөгөө өгөх;

32.4.3.гэрлэгчдийг шаардлагатай сургалт, мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулах;

32.4.4.хуульд заасан бусад арга хэмжээ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дараах агуулгатай 144¹ дүгээр зүйлийг нэмсүгэй:

“144¹ дүгээр зүйл. Хүүхэд үрчлэх хүсэлт гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

144¹.1. Хүүхэд үрчлэх хүсэлтийг хүүхдийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

144¹.2. Хүүхэд үрчлэх тухай хүсэлтэд хүүхэд үрчлэх болсон шалтгааныг тодорхой дурдаж, холбогдох нотлох баримт, эрх бүхий байгууллагын үнэлгээ, дүгнэлтийг хавсаргана.

144¹.3. Зохигчийн төлөөлөгч, өмгөөлөгч болон хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллагын төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.

144¹.4. Шүүх хүүхдийг үрчлүүлэх шийдвэр гаргахдаа эрх бүхий байгууллагын үнэлгээ, дүгнэлтийг харгалзаж шийдвэр гаргана.”

2 дугаар зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1.4 дэх заалтын “хүүхэд” гэсний дараа “үрчлүүлэх,” гэж нэмсүгэй.

3 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

“132.4. Харин гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон, эсхүл эхнэр, нөхөр хоёрын хэн нэг нь сураггүй алга болсон, эсхүл эрх зүйн чадамжаа хязгаарлуулсан, эсхүл гурваас доошгүй жилээр хорих ялаар шийтгүүлсэн, эсхүл хүйсээ өөрчилсөн бол шүүгч энэ зүйлийн 132.1-д заасан арга хэмжээг авалгүйгээр гэрлэлтийг цуцалж болно.”

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.2, 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/126 дугаар зүйлийн 126.2.6 дахь заалт:

“126.2.6.тэтгэвэр, тэтгэмж.”;

2/127 дугаар зүйлийн 127 дугаар зүйл:

“127.1.7.хамтран өмчлөх дундын эд хөрөнгөөр худалдан авснаас бусад үнэт цаас, ногдол хувь.

127.3.Хүүхдийн хуваарьт эд хөрөнгийг эцэг, эх нь түүний эрх, ашиг сонирхолд нийцүүлэн, захиран зарцуулах үүргийг хүлээнэ.

127.4.Эцэг, эх нь гуравдагч этгээдтэй эрх зүйн харилцаанд орохдоо хүүхдийн хуваарьт хөрөнгийн хувьд өмчлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж, үр дагаврыг нь хариуцах бөгөөд хүүхдийн ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулсны улмаас түүнд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

127.5.Хүүхэд насанд хүрснээс хойш 10 жилийн дотор өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах эрхтэй.

127.7.Хүүхдийн хуваарьт эд хөрөнгөөр эцэг, эхийн бусдын өмнө хүлээх үүргийг барагдуулах, нөхөн төлүүлэхийг хориглоно.”

2 дугаар зүйл.Иргэний хуулийн 129 дугаар зүйлийн 129.3 дахь хэсгийн “тодорхойлохдоо” гэсний дараа “, “гэрлэлт цуцлуулах болсон шалтгаан, нөхцөл” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Иргэний хуулийн 127 дугаар зүйлийн “127.3” гэсэн дугаарыг “127.6” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Иргэний хуулийн 125 дугаар зүйлийн 125.1 дэх хэсгийн, 126 дугаар зүйлийн 126.2.4 дэх заалтын, мөн зүйлийн 126.3 дэх хэсгийн, мөн зүйлийн 126.4 дэх хэсгийн, 129 дүгээр зүйлийн 129.1.3 дахь заалтын “бусад” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Иргэний хуулийн 132, 133 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг